

ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ БОДЛОГО, ХӨТӨЛБӨРТ ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ АСУУДАЛ ТУСГАГДСАН БАЙДАЛ, ТЭДГЭЭРИЙН ХЭРЭГЖИЛТ

*Д.Сэржмядаг Гамшиг судлалын хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор*

Хураангуй

Монгол Улсын төрөөс гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд, олон нийтийг оролцуулах талаар ихээхэн анхаарал хандуулж олон бодлогын баримт бичигт энэ асуудлыг тусган хэрэгжүүлж байна. Гамшгаас хамгаалах салбарын суурь хуулиудад иргэд, олон нийтийн оролцоотой холбоотой зохицуулалт тооны болон чанарын хувьд эрс нэмэгджээ. Гамшгийн эрсдэлийг бууруулах бодлого, хөтөлбөрт туссан зорилт, арга хэмжээний хэрэгжилт харьцангуй сайн байгаа бөгөөд цаашид олон нийтийн гамшгийн эрсдэлийн үнэлгээ, төлөвлөлт, хэрэгжилтэд оролцоог хангахад анхаарах шаардлагатай.

Сүүлийн жилүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийт, иргэдийн оролцоог хангахад чиглэсэн эрхзүйн болон бодлогын шинэчлэлийг эрчимтэй явуулж, хэрэгжилтийг ханган ажилласны дүнд онцгой байдлын байгууллагад хандах иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна.

Оршил

Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг үр дүнтэй байхад хамгийн чухал зүйл бол иргэд, олон нийтийн оролцоо гэж дэлхий нийтээрээ үзэж байна. Хүн ам таруу алслагдмал, харилцаа холбоо сул хөгжсөн Монгол орны нөхцөлд аливаа аюулт үзэгдэл, ослын үед иргэд мэргэжлийн байгууллагын тусламж ирэхээс өмнө эд хөрөнгө болон эрүүл мэндээрээ хохирох цаашлаад эндэх хүртэл эрсдэл өндөр байдаг тул иргэдийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирол багатай даван туулах чадварыг нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага харьцангуй өндөр байдаг. Монгол Улсын төрөөс гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэд, олон нийтийг оролцуулах талаар ихээхэн анхаарал хандуулж олон бодлогын баримт бичигт энэ асуудлыг тусгасан байна. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримталж буй дараах бодлогын баримт бичигт иргэдэд чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах асуудлыг авч үзсэн байна.


Монгол Улсын УИХ-аар Галын аюулгүй байдлын тухай хуулийг 2015 оны 07 дугаар сарын 02-ны өдөр, Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр тус тус батлуулсан. Эдгээр суурь хуулиудын үзэл баримтлал гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшгийн эрсдэлийг бууруулахад бүхэлдээ чиглэж гамшгийн эрсдэлийн удирдлагын засаглалыг сайжруулах, нэн ялангуяа иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэгдсэн.

Эдгээр хуулиудад иргэдийн оролцоотой холбоотой эрхзүйн зохицуулалт тооны хувьд хэрхэн нэмэгдсэнийг авч үзвэл иргэд, олон нийтийн оролцооны зохицуулалт Гамшгаас хамгаалах тухай хуулинд 2 зүйл, 9 заалтаас, 4 зүйл, 24 заалт болж нэмэгдэж, Галын аюулгүй байдлын тухай хуульд 2 зүйл 7 заалтаас 3 зүйл 17 заалттай болсон байна.



Нэг. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны эрхзүйн орчин дахь олон нийт, иргэдийн оролцоог хангахад чиглэсэн зохицуулалт

Зураг 1. Гамшгаас хамгаалах тухай болон Галын аюулгүй байдлын тухай хууль дахь иргэд, олон нийтийн оролцоог хангахтай холбоотой эрхзүйн зохицуулалтын тоо



Гамшгаас хамгаалах тухай хуулийн шинэчлэлийн хүрээнд иргэдийн оролцооны зохицуулалт чанарын хувьд дараах чиглэлд өөрчлөгдсөн байна. Үүнд:

1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагааны зарчимд "иргэдийн оролцоонд тулгуурлах"¹

2. Иргэн 8 үүрэг хүлээдэг байсныг **5 эрх эдэлж 7 үүрэг хүлээх**²


3. **Гамшгаас хамгаалах сайн дурын хэсэг байгуулах, гишүүнээр элсэх, гамшгаас хамгаалах дундын хөрөнгийн сан үүсгэх**³ зэргийг дурьдаж болно. Түүнээс гадна иргэдэд гамшгаас урьдчилан сэргийлэх арга ухаан эзэмшүүлэхэд чиглэсэн гамшгаас хамгаалах сургалтыг иргэний⁴ гэсэн ангиллаар явуулах бөгөөд "иргэний сургалтыг тухайн баг, хорооны Засаг дарга⁵" хариуцан зохион байгуулж явуулахаар хуульчилсан.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн А/130 дугаар тушаалаар **"Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр"**-ийг батласан. Энэ тушаалын хавсралтанд гамшгаас хамгаалах иргэдийн

сургалтын хөтөлбөрийг баталсан байна. Хөтөлбөрөөс харахад *иргэний сургалтын агуулга нь* гамшгаас өөрийгөө хамгаалах, бусаддаа тусламж, дэмжлэг үзүүлэх, аюулгүй орчинд амьдрах дадлыг хэвшүүлэх, өрхийн түвшинд гамшгийн бэлэн байдлыг хангах чадвар, хандлагыг олгох, гамшгаас хамгаалахад чиглэсэн орон нутгийн үйл ажиллагаанд оролцох, дэмжлэг үзүүлэхэд ерөнхийдөө чиглэжээ.

Дээрх тушаалын хавсралтад “баг, хорооны Засаг дарга өөрийн эрхийн хүрээнд хорооны нийгмийн ажилтанд иргэдийн сургалтыг хариуцуулна. Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллага арга зүйн зөвлөмжөөр хангаж, олон улсын байгууллагын төсөл, хөтөлбөрийн хүрээнд баг, хорооны нийгмийн ажилтнуудыг иргэдэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургагч багшаар бэлтгэнэ. Үүнд: Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг мөн татан оролцуулна” гэж зааж өгсөн байна. Энэ дагуу иргэнд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалтын дараах тогтолцоо бүрдээд байна.

Зураг 2. Гамшгаас хамгаалах иргэдийн сургалт, сурталчилгааны тогтолцооны "ГЭР" загвар



Иргэдийн сургалтыг баг, хорооны засаг дарга, нийгмийн ажилтан явуулах эрхзүйн зохицуулалттай байгаа бөгөөд мөн үүнтэй зэрэгцээд сургаж бэлтгэгдсэн сайн дурын идэвхтэн, төрийн бус байгууллага, олон улсын байгууллага болон дээрх байгууллагаас бэлтгэсэн мэдээллийг дамжуулах хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэсэн үндсэн 6 сувгаар иргэд гамшгаас урьдчилан сэргийлэх талаар мэдлэг, мэдээлэл авч байна.

Онцгой байдлын ерөнхий газарт ирүүлсэн 2015-2019 онд гамшгаас хамгаалах чиглэлээр иргэдэд зохион байгуулсан сургалтын талаарх мэдээллийг 1-р хүснэгтэд харуулав.

Хүснэгт 1. Иргэдэд явуулсан гамшгаас хамгаалах сургалт

Он	Сургалтын тоо	Сургалтын цаг	Хамрагдсан иргэдийн тоо
2015	683	1470	269802
2016	527	1112	145507
2017	1283	2598	167771
2018	814	1648.2	204014
2019	888	2056	128933
Дундаж	839	1776	183250

Сүүлийн 5 жилийн мэдээнээс харахад улсын хэмжээнд зохион байгуулсан нийт гамшгаас хамгаалах ангиллын сургалтын ойролцоогоор арав гаруй хувь нь иргэдийн сургалт байдаг, түүнд хамрагдагсдын 40 орчим хувь иргэд байдаг байна. Улсын хэмжээнд 800 гаруй сургалтыг зохион байгуулж ойролцоогоор 200 мянган хүн энэ ангиллын сургалтанд хамрагджээ.

Хоёр. Иргэдэд чиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах бодлогын баримт бичиг

1. Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого

Манай улсын хувьд олон нийт, иргэдэд гамшгийн эрсдэлийг бууруулах ойлголт, мэдлэг олгох асуудал нь “Хёогогийн үйл ажиллагааны хүрээ” баримт бичгийн үзэл санаатай нийцүүлэн УИХ-аас 2011 онд батлан гаргасан “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого”-ын үндсэн чиглэлд “...хүн амыг аюулгүй амьдрах ухаанд сургах...” гэж тусгалаа олж хэрэгжиж ирсэн. Энэхүү бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 30 дугаар тогтоолоор “Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан.

Тус төлөвлөгөөнд гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагаанд иргэдийг оролцуулахтай холбогдуулж

1.1-д Иргэдэд түшиглэсэн гамшгаас хамгаалах менежментийг хөгжүүлэх, 2.5-д Гамшгаас хамгаалах талаарх иргэдийн мэдлэгийг дээшлүүлэх, ардын уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх гэсэн 2 арга хэмжээг 2012-2020 онд хэрэгжүүлж байна.

Энэ 2 арга хэмжээний хэрэгжилтийг 2019 оны байдлаар авч үзвэл гамшгаас хамгаалах ардын уламжлалт арга ухааныг түгээн дэлгэрүүлэх чиглэлд дорвитой ажил хийгдээгүй хэрэгжилт хангалтгүй байна.

2. Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол

Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги

Дэлхий улс орнууд 2015 онд “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагаа хүрээ” баримт бичигт дэвшүүлсэн дэлхий нийтээр хэрэгжүүлэх 7 зорилт, үйл ажиллагааны 4 тэргүүлэх чиглэлийг үндэсний хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн өөрсдийн чадавх, нөөц бололцоонд тулгуурлан хэрэгжүүлэхээр үүрэг амлалт авсан. Энэ хүрээнд Онцгой байдлын ерөнхий газраас “Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги (2017-2030)”-ийг боловсруулан Засгийн газрын 2017 оны 355 дугаар тогтоолоор батлуулсан.

Стратегийн зорилго нь Гамшгийн эрсдэлийг бууруулах Сендайн үйл ажиллагааны хүрээг Монгол Улсад үе шаттай хэрэгжүүлэх, үндэсний болон орон нутгийн түвшинд гамшгийн эрсдэлийг бууруулах, шинэ эрсдэл үүсэхээс сэргийлэх, гамшгаас хамгаалах үндэсний болон орон нутгийн чадавхыг бэхжүүлэхэд оршино.

Энэхүү стратеги нь Сендайн үйл ажиллагааны хүрээний 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд 9 зорилтыг дэвшүүлсэн ба 2017-2020, 2020-2025, 2025- 2030 он хүртэл гэсэн 3 үе шаттай хэрэгжинэ.

Стратегийн эхний үе шатанд буюу 2017-2020 онд Гамшгийн эрсдэлийг ойлгох гэсэн нэгдүгээр үндсэн чиглэлийн хүрээнд **"иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг олгох сургалт аргазүйн төвийг байгуулж, ажиллуулах"** гэсэн арга хэмжээг хэрэгжүүлэхээр оруулж одоогоор 2 ийм төвийг байгуулан ажиллуулж байна.

3. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр

Монгол Улсын Засгийн газар “Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр”-ийг 2015 оны 7 дугаар сарын 20- ны өдрийн 303 дугаар тогтоолоор 2015-2025 онд хэрэгжүүлэхээр баталсан.

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, сургалт, сурталчилгаа, үйл ажиллагаанд иргэдийг оролцуулан, тэдний мэдлэг, чадварыг дээшлүүлэх, аюулгүй амьдрах ухамсарт соёл болон болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх замаар гамшгийн эрсдэлийг бууруулахад оршино.

Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилтыг дэвшүүлсэн.

Үүнд:


1. Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах эрх зүйн орчин, тогтолцоог бүрдүүлэх;
2. Гамшгийн эрсдэлийг бууруулах олон нийтийн сургалт, сурталчилгааг бүх түвшинд шат дараалан зохион байгуулах;
3. Олон нийтийн оролцоонд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх.
4. Уур амьсгал, ус, цаг уурын гаралтай аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг шуурхай мэдээлэх тогтолцоог бэхжүүлэх;

5. Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийтийн оролцоо, идэвх, санаачилгыг дэмжих;

6. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх зэрэг болно.

Монгол Улсын Шадар сайдын 2016 оны 50 дугаар тушаалаар батлагдсан тус үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө батлагдсан. Төлөвлөгөөнд хөтөлбөрийн 6 зорилтын хүрээнд хамаарах 41 ажил арга хэмжээг 2016-2020 онд хийхээр төлөвлөсний 2019 оны хэрэгжилтийг биелэлт 91.3 хувьтай гэж дүгнэгджээ.

Зураг 3. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилтын биелэлтийн хувь, 2019 оны байдлаар



Нийт 41 арга хэмжээнээс дараах 7 арга хэмжээ 2019 оны байдлаар биелэлт бүрэн хангагдаагүй буюу 70%-аас доош хэрэгжилттэй дүгнэгдсэн байна.

Хүснэгт 2. Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй байгаа ажил

№	Арга хэмжээ, биелэлтийн хувь	Хугацаа	Хариуцах эзэн	Хамтран хэрэгжүүлэгч
3.4	Сумдад гамшгаас урьдчилан сэргийлэх, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд зарцуулах гамшгаас хамгаалах сан, аж ахуйн нэгж, байгууллага, хоршоо, нөхөрлөл, малчид, иргэдийн бүлгийн дунд гамшгийн эрсдэлийг бууруулах дундын хөрөнгийн санг тус тус байгуулахыг дэмжих /40%/	2016-2020	ХХААЯ, БОНХАЖЯ, ОБЕГ	УУЯ, Аймаг, нийслэл, сум дүүргийн засаг дарга, ААНБ, иргэд

3.6	Гамшгаас хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагыг түшиглэн гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх аргачлалыг хэрэглэгч, олон нийтийн оролцоотой боловсруулах, гамшгаас хамгаалах судалгаа, шинжилгээний ажлыг орчин үеийн техник, технологийг ашиглан шинжлэх ухааны үндэслэлтэйгээр гүйцэтгэх /40%/	2016-2018	БСШУЯ, ОБЕГ	ШУА, Иргэний нийгмийн байгууллага
3.7	Гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, үнэлж дүгнэх аргачлалыг хэрэглэгч, олон нийтийн оролцоотой боловсруулж хэрэгжүүлэх /70%/	2016-2020	ОБЕГ	ШУА
4.2	Газар ашиглалт, бэлчээрийн нөхцөл байдлыг сансрын болон зайнаас тандан судлах технологийг ашиглан судлах, үр дүнг холбогдох төр, захиргааны байгууллага, иргэд, малчдад түгээх /70%/	2016-2020	ХХААЯ, УЦУОШГ	БОНХАЖЯ, Аймаг, нийслэл, сум дүүргийн засаг дарга
6.3	Мэргэжлийн байгууллагуудын судалгаанд үндэслэн орон нутгийн удирдлага, иргэд, хэрэглэгч, олон нийтийн байгууллагын тусламжтайгаар газар хөдлөлт, үерийн аюулын эрсдэлийн зураглалыг боловсруулах /40%/	2016-2020	БХБЯ, БОНХАЖЯ, ОБЕГ	Засаг дарга, ААНБ, иргэний нийгмийн байгууллага
6.7	Дэлхийн дулаарал, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас шинээр болон дахин сэргэж байгаа халдварт өвчин, тэдгээрийн халдварын мониторингийн сүлжээг бий болгох, мэдээллийн сан бүрдүүлж, сургалт сурталчилгааг зохион байгуулах /40%/	2016-2020	ЭМСЯ, ХХААЯ, МХЕГ	ОБЕГ, Аймаг, нийслэл, сум дүүргийн засаг дарга, Ойн анги, Шинжлэх ухааны болон иргэний нийгмийн байгууллага
6.9	Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй байгаль экологийн нөлөөллийн үнэлгээг хэрэглэгч, олон нийтийн оролцоонд түшиглэн тусгайлсан бүс нутаг, газрын хэмжээнд гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх /40%/	2016-2020	БОНХАЖЯ, УЦУОШГ	

Эх сурвалж: ОБЕГ, ОНОГЭБ үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний биелэлтийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тухай 2018, 2019 оны тайланд

үндэслэв.

Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөрийн зорилтуудын биелэлт харьцангуй сайн байгаа нь харагдаж байна. Энэ хөтөлбөрийн хувьд цаашид анхаарах шаардлагатай ажил нь

- Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан гамшгийн эрсдэлийг бууруулах үйл ажиллагааг тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжилтийг зохион байгуулах, шинэчлэх.

- Гамшгийн эрсдэлийг бууруулах төлөвлөгөөг тухайн орон нутгийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөтэй уялдуулж, хэрэгжүүлэх арга хэмжээ авах.

- Байгаль хамгаалах нөхөрлөлүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулах сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах, бэлэн байдлын төлөвлөгөөтэй болгох, чадавхижуулах зэрэг байна.

Энэ үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэд, олон нийт рүү чиглэж авч хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээг дараах хүснэгтэд тоймлох

**Хүснэгт 3. Гамшгийн эрсдэлийг бууруулахад иргэдийг оролцуулах талаар
хэрэгжүүлсэн томоохон арга хэмжээ**

Зорилтот бүлэг	Авч хэрэгжүүлсэн томоохон ажил
Хүүхэд	ЕБС-д үзэх "Аюулгүй амьдрах ухаан" сургалтын хөтөлбөрийг БСШУС-ын сайдын 2018.04.06-ны өдрийн А/181 тоот тушаалаар батлуулсан. Жайка төслийн хүрээнд багшийн гарын авлагыг боловсруулсан. Одоо багшид зориулсан сургалтын багц хэрэглэгдэхүүн боловсруулж байна. Гамшгийн эрсдэлийг бууруулахад хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор улсын хэмжээнд нийслэлийн 6 дүүрэг, 91 суманд 143 ерөнхий боловсролын сургууль дээр 3000 гаруй гишүүнтэй Өсвөрийн аврагч бүлэг ажиллаж, эдээр хүүхдийн дунд "Өсвөрийн аврагч" тэмцээнийг 2 үе шаттай зохион байгуулж байна.
Оюу тан сурагчид	Бүх их дээд сургууль, коллежид Гамшгаас хамгаалах менежмент хичээлийг 1-1,5 багц цаг судлаж байна. 83 МСҮТ, их дээд сургууль, коллежийн 92 багшийг Гамшгаас хамгаалах менежмент хичээлийн сургагч багшаар бэлтгэв
Иргэд	ОБЕГ, МУЗН-тэй хамтран Гамшгаас хамгаалах сайн дурын идэвхтэн 450 хүнийг жил бүр сургасан nema.gov.mn ; www.ontsgoisur.gov.mn цахим хуудсыг ажиллуулж эдгээрт байрлах 314 хичээл, 1328 сургалт, мэдээ мэдээлэлд өдөрт дунджаар 1500-2000 хүн, сард 35-50 мянган хүн тогтмол хандаж байна "Онцгой байдлын цаг" 15 минутын нэвтрүүлгийг 14 хоногийн давталттайгаар МҮОНТВ-ийн 1, 2-р сувгаар, Өлзий телевизээр тус тус тогтмол нэвтрүүлэн ажиллаж байна. "Онцгой мэдээ" сонины нийт 100 гаруй дугаарыг эрхлэн гараж уншигч олны хүртээл болгосон. Гамшгаас урьдчилан сэргийлэх чиглэлээр жилд дунджаар 2000 гаруй удаагийн мэдээ, мэдээлэл, ярилцлага, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын мэдээ, цаг үеийн мэдээ, мэдээлэл, сэрэмжлүүлгийг өдөр тутмын сонин хэвлэл, телевиз, радио, байгууллагын цахим сайт болох

	meta.gov.mn болон бусад цахим сайтууд, фэйсбүүк хуудсанд байршуулан ажилласан. Олон нийтийн оролцоотой сум, сургуулийн гамшгийн эрсдэлийг үнэлэх, үнэлгээнд тулгуурлан эрсдэлийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргах аргачлал боловсруулж иргэд сумын Гамшгийн эрсдэлийн тойм судалгаа/ерөнхий үнэлгээнд оролцож байна Цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдэл, гол, мөрөн, нуурын мөс цөмрөх, усны ослын болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх тухай мэдээг 20 гаруй телевизийн өдөр тутмын 6 сонин, вэб сайтаар дамжуулж, байна Монгол улсын 330 сумын 1820 багийг SMS системд холбосон бөгөөд иргэд, малчид гар утсан дээрээ цаг агаарын мэдээ, цаг агаарын урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэх мэдээ, ган, зуд, бэлчээрийн ургац гэх мэт 12 төрлийн мэдээлэл бүхий "Багц мессеж" ийг багийн түвшинд хүлээн авах боломжтой болсон ANHAAR аппликейшн гар утсандаа суулган 8 төрлийн гамшиг, аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх хичээлтэй танилцах боломж бүрдсэн Багуудад хөршийн бүлэг, ойн бүлэг нөхөрлөл бий болж багийн Засаг даргад бүртгүүлсэн байна.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Харааны бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулж Брайль үсэгтэй гамшгийн үед өөрийгөө болон бусдыг авран хамгаалах, хариу арга хэмжээ авах талаар өгүүлсэн өрхийн бэлэн байдлын номыг гаргасан Хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон тэдний асран хамгаалагч 200 иргэнд сургалт явуулсан Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээлэл авах эрх ашгийг хүндэтгэх зорилгоор "Онцгой байдлын цаг" нэвтрүүлгийг дохионы хэлний орчуулгатайгаар бэлтгэн хүргэж байна

Дүгнэлт

Сүүлийн жилүүдэд гамшгийн эрсдэлийг бууруулахад олон нийт, иргэдийн оролцоог хангах асуудлыг авч үзсэн хэд хэдэн бодлогын баримт бичгүүдийг батлуулан ажилласны үр дүнд гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаанд хандах болон онцгой байдлын байгууллагад хандах иргэдийн сэтгэл ханамж дээшилсэн байна. Тухайлал, Гамшиг судлалын хүрээлэнгээс 2010 болон 2019 онд явуулсан Онцгой байдлын байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны дүнгээс харахад Гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгааг 2010 онд иргэд маш сайн, сайн гэж **38,5%** нь, муу, маш муу гэж **16,7%** нь үзсэн байсан бол 2019 онд маш сайн, сайн гэж **61%** нь, муу, маш муу гэж **6,9%** нь үзсэн.

Өөрөөр хэлбэл гамшгаас хамгаалах сургалт, сурталчилгаанд сэтгэл ханамжтай иргэдийн хувь сүүлийн 10 жилд мэдэгдэхүйц нэмэгдсэн байна.

Онцгой байдлын байгууллагын үйл ажиллагаанд өгсөн иргэдийн сэтгэл ханамжийн үнэлгээ нь 2010 оны судалгаагаар 3 хүн тутмын 1 нь (30%) сэтгэл ханамжгүй гэж үзэж байсан бол 2019 оны судалгаанд оролцсон иргэдийн таван хүн тутмын нэг нь (22%) байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй гэж сөрөг үнэлгээ өгчээ. Эндээс тус байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл ханамжгүй байгаа иргэд харьцангуй цөөрсөн байгаа нь харагдаж байна.

Хэдий тийм боловч хүн ам нь тархай бутархай сууршилтай Монгол орны нөхцөлд иргэд гамшгийг хэрхэн эрсдэл багатай даван туулах вэ гэдгийг судлан аюулгүй амьдрах арга ухаан, ур чадварт суралцах асуудал хамгийн чухал хэвээр байна. Иймд иргэдэд гамшгаас өөрсдийгөө болон бусдыгаа, аж ахуйгаа хамгаалах мэдлэг боловсролыг зөвхөн сургалт, сурталчилгаагаар олгохоос гадна уг мэдлэгээ өдөр тутамдаа аюулгүй амьдрах хэвшил дадал болгоход чиглүүлж ажиллах шаадлагатай.

Ашигласан эх сурвалжийн жагсаалт

- Гамшгаас хамгаалах тухай хууль, 2017
- Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015
- "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого" УИХ-ын 2011 оны 22 дугаар тогтоол
- "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө" Засгийн газраас 2012 оны 30 дугаар тогтоол, хэрэгжилтийн тайлан -2018
- "Гамшгаас хамгаалах талаар төрөөс баримтлах бодлого хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоол, хэрэгжилтийн тайлан- 2018
- "Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр" Засгийн газрын 2015 оны 303 дугаар тогтоол, хэрэгжилтийн тайлан -2018
- "Гамшгаас хамгаалах ангиллын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр" Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2016 оны А/130 дугаар тушаал
- Д.Сэржмядаг нар., (2019) Онцгой байдлын асуудал эрхэлсэн байгууллагын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгааны тайлан